



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/188/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Гэрээт ажилтан: Ц.Лүндэгмаа

Утас: 99026829

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.27 № 1-6/108

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Ц.САРУУЛСАЙХАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

440020490

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>572,545,100.00</u>	<u>574,266,200.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	572,545,100.00	574,266,200.00
351	Түүхий эд материал	567,061,800.00	567,061,800.00
35110	Тусгай зориулалттай материал	567,061,800.00	567,061,800.00
354	Хангамжийн материал	5,483,300.00	7,204,400.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	1,281,100.00
35420	Аж ахуйн материал	2,335,300.00	2,335,300.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	440,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,148,000.00	3,148,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,090,183.03</u>	<u>32,145,987.23</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	31,090,183.03	32,145,987.23
392	Биет хөрөнгө	31,090,183.03	32,145,987.23
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,499,999.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,328,088.00	11,676,288.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-49,509,964.97	-3,413,340.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,184,200.00	2,507,190.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-912,140.00	-1,124,150.00
39301	Програм хангамж	800,000.00	800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-800,000.00	-800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>603,635,283.03</u>	<u>606,412,187.23</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>603,635,283.03</u>	<u>606,412,187.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	603,635,283.03	606,412,187.23
512	Хуримтлагдсан үр дүн	603,292,928.03	606,069,832.23
51210	Өмнөх үеийн үр дүн	603,292,928.03	603,292,928.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,776,904.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	342,355.00	342,355.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>603,635,283.03</u>	<u>606,412,187.23</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>130,263,728.00</u>	<u>79,658,119.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>64,400,728.00</u>	<u>7,011,419.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	39,400,728.00	5,938,429.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,400,728.00	5,938,429.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,400,728.00	5,938,429.00
122	Тусламжийн орлого	25,000,000.00	1,072,990.00
122001	Хандив тусламж /дотоод/	25,000,000.00	1,072,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	<u>65,863,000.00</u>	<u>72,646,700.00</u>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,863,000.00	72,646,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,863,000.00	72,646,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>106,161,266.52</u>	<u>76,881,214.80</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>106,161,266.52</u>	<u>76,881,214.80</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,946,955.42	75,230,940.13

Замын-Үүд сумын ЗАА-ны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,035,673.00	53,407,800.40
210101	Үндсэн цалин	42,638,670.00	53,407,800.40
210104	Урамшуулал	1,397,003.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,436,057.00	6,649,721.00
210201	Тэтгэврийн даатгал	3,856,514.00	5,612,729.00
210202	Тэтгэмжийн даатгал	356,719.00	250,812.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	266,403.00	220,706.00
210204	Ажилгүйдлийн даатгал	87,192.00	63,847.00
210205	Эрүүл мэндийн даатгал	869,229.00	501,627.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,555,522.90	4,217,103.93
210401	Бичиг хэрэг	1,893,920.00	1,710,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,632,000.00	2,155,385.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	149,342.90	265,518.93
210404	Ном, хэвлэл	26,860.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	124,000.00	85,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	729,400.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,107,540.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,646,640.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,460,900.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,193,838.00	6,234,929.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,977,838.00	5,734,929.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,618,324.52	4,721,385.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,992,173.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	992,000.00	489,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,634,151.52	4,231,885.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,214,311.10	1,650,274.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,214,311.10	150,274.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	24,102,461.48	2,776,904.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	24,102,461.48	2,776,904.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>106,136,728.00</u>	<u>78,585,129.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,273,728.00	5,938,429.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,273,728.00	5,938,429.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,273,728.00	5,938,429.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,273,728.00	5,938,429.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,863,000.00	72,646,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,863,000.00	72,646,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,863,000.00	72,646,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>106,136,728.00</u>	<u>78,585,129.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,136,728.00	78,585,129.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,922,416.90	76,934,854.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,693,318.00	53,407,800.40
210101	Үндсэн цалин	42,296,315.00	49,871,894.78
210104	Урамшуулал	1,397,003.00	3,535,905.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,436,057.00	6,649,721.00

Замын-Үүд сумын ЗАА-ны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	3,696,699.00	4,522,673.00
210202	Тэтгэмжийн даатгал	356,719.00	532,076.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	426,218.00	425,662.00
210204	Ажилгүйдлийн даатгал	87,192.00	105,153.00
210205	Эрүүл мэндийн даатгал	869,229.00	1,064,157.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,820,802.90	5,352,303.93
210401	Бичиг хэрэг	1,510,800.00	2,946,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,632,000.00	2,095,385.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	221,942.90	265,518.93
210404	Ном, хэвлэл	306,060.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	4,300,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,300,600.00
2107	Томилолт, зочны зардал	3,107,540.00	00.00
210702	Дотоод албан томилолт	1,623,400.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,484,140.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,020,726.00	6,734,929.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,804,726.00	6,234,929.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,843,973.00	489,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,851,973.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	992,000.00	489,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,214,311.10	1,650,274.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,214,311.10	150,274.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	342,355.00	603,292,928.03	603,635,283.03
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	342,355.00	603,292,928.03	603,635,283.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	342,355.00	603,292,928.03	603,635,283.03
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,776,904.20	2,776,904.20
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	342,355.00	606,069,832.23	606,412,187.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,202,500.00	72,496,425.33	18,706,074.67	79.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,202,500.00	72,496,425.33	18,706,074.67	79.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,702,500.00	70,996,425.33	18,706,074.67	79.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,384,300.00	53,407,800.40	5,976,499.60	89.94
210101	Үндсэн цалин	56,428,300.00	49,871,894.78	6,556,405.22	88.38
210104	Урамшуулал	2,956,000.00	3,535,905.62	-579,905.62	119.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,354,400.00	6,649,721.00	1,704,679.00	79.60
210201	Тэтгэврийн даатгал	5,880,000.00	4,522,673.00	1,357,327.00	76.92
210202	Тэтгэмжийн даатгал	619,200.00	532,076.00	87,124.00	85.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	494,400.00	425,662.00	68,738.00	86.10
210204	Ажилгүйдлийн даатгал	123,600.00	105,153.00	18,447.00	85.08
210205	Эрүүл мэндийн даатгал	1,237,200.00	1,064,157.00	173,043.00	86.01
2104	Хангамж, бараа материалын зардал	8,485,400.00	5,352,303.93	3,133,096.07	63.08
210401	Бичиг хэрэг	3,024,000.00	2,946,400.00	77,600.00	97.43
210402	Тээвэр, шатахуун	2,100,000.00	2,095,385.00	4,615.00	99.78
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,261,000.00	265,518.93	1,995,481.07	11.74
210404	Ном, хэвлэл	750,400.00	45,000.00	705,400.00	6.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	350,000.00	00.00	350,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,300,600.00	199,400.00	95.57
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,300,600.00	199,400.00	95.57
2107	Томилолт, зочны зардал	3,178,400.00	00.00	3,178,400.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,178,400.00	00.00	3,178,400.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,200,000.00	796,500.00	1,403,500.00	36.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,700,000.00	296,500.00	1,403,500.00	17.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	00.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3600000.00	489500.00	3,110,500.00	13.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,100,000.00	00.00	2,100,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	489,500.00	1,010,500.00	32.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1500000.00	1500000.00	00.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91,202,500.00	72,646,700.00	18,555,800.00	79.65
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,202,500.00	72,646,700.00	18,555,800.00	79.65
132001	Орон нутгийн төсвөөс	91,202,500.00	72,646,700.00	18,555,800.00	79.65
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	04.00	04.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	00.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	5,938,429.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	5,938,429.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	5,938,429.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	5,938,429.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5,938,429.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЗАА-ны дарга Ц.Саруулсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт ажилтан Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 20-ны өдрийн 2/04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутагт болох худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах

- Хотын захирагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хот байгуулалт, дэд бүтцийн талаар арга зүйн удирдлагаар хангаж хууль тогтоомж бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт удирдан зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны батлагдсан төсвийн дүнгийн 96,502.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 443.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 97,739.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 965.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд нийт зардлын дүнгийн 76,881.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 768.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 908.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	572,545.1	574,266.2	1,721.1
Үндсэн хөрөнгө	31,090.2	32,146.0	1,055.8
Нийт хөрөнгө	603,635.3	606,412.2	2,776.9
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	603,635.3	606,412.2	2,776.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	603,635.3	606,412.2	2,776.9

Бараа материалын дансны үлдэгдэл 574,266.2 мянган төгрөг болж 1,721.1 мянган төгрөгөөр өссөн бичиг хэргийн материалын үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 32,146.0 мянган төгрөг болж 1,055.8 мянган төгрөгөөр өссөн нь 5,287.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 47,616.5 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж 4,231.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь 5,287.7.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь урсгал төсвийн худалдан авалтаар 4,214.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, шилжүүлэн авсан тоног төхөөрөмж 750.0 мянган төгрөг, 322.9 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл байна. Үндсэн хөрөнгө 47,616.5 мянган төгрөгөөр хасагдсан нь тоног төхөөрөмж данснаас 17,616.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан 30,000.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 606,412.2 мянган төгрөг болж 2,776.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

ЗАА-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар өмнөх онд 130,263.7 мянган төгрөг, тайлант онд 79,658.1 мянган төгрөг бөгөөд нийт орлого өмнөх оноос 50,605.6 мянган төгрөгөөр буюу 38.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орлого 50,605.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд тайлант оноос өндөр төсөв баталсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 29,280.1 мянган төгрөгөөр буюу 27.6 хувиар буурсан байна. Төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр үндэслэж бодитой тооцоогүйгээс өмнөх оны зардлын төсөв өндөр байсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 97,502.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 97,502.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн дүнгээр сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 12/05 дугаар тогтоолоор ЗАА-ын төсвийг 97,502.5 мянган төгрөгөөр баталсан ба 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 02/12 дугаар тогтоолоор 91,202.5 мянган төгрөг болгон анхны баталсан төсвийг 6300.0 мянган төгрөгөөр бууруулж өөрчилсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн төсвөөс төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 91,202.5 мянган төгрөгийн төсөв баталж төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 72,646.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 72,496.4 мянган төгрөгийг зарцуулж 150.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 72,496.4 мянган төгрөг буюу 79.5 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс 18,555.8 мянган төгрөгийн санхүүжилт дутуу орсонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу цахим тендерийн орлого 5,938.4 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж, худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажилласан гишүүдэд ажилласан цагийн хөлс, зар сурталчилгааны самбаруудын эвдрэл гэмтлийг засах, өнгө үзэмжийг сайжруулах, ажлын хөлс, сургалт, шатахууны зардал зэрэгт 5,938.4 мянган төгрөг зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 461.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг биелүүлсэн, 7876.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагын 1-ийг барагдуулж 7876.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хэрэгжүүлээгүй, өмнөх онд өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	461.5	1	461.5	0	0.0	100
Албан шаардлага	2	7,876.0	1	0.0	1	7,876.0	50
Зөвлөмж	1	0.0	0	0.0	1	0	0
Нийт дүн	4	8,337.5	2	461.5	2	7,876.0	

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,172.2 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 5,172.2 мянган төгрөгийн алдааг залруулж, өмнөх оны 1 албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага тус тус хүргүүллээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайланд цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлын дүнг 53,407.8 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 6,649.7 мянган төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлын дүнг 55,993.9 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлын дүнг 4,063.6 мянган төгрөгөөр зөрүүлж тайлагнасан байна. Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлын дүнг 2586.1 мянган төгрөгөөр бууруулж, НДШ-ийн дүнг 2,586.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тус тус залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа буюу өмнөх оны албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага тус тус хүргүүлээ.

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд цахим тендерийн хураамжийн орлого 5,938.4 мянган төгрөг орсон бөгөөд үйл ажиллагааны орлогоор төлөвлөж төсөв батлуулаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж биелэгдээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасны дагуу нэг албан шаардлага бичлээ.

2. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүнтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Өмнөх оны аудитаар өгсөн “Зураг төсөв, агаарын шугамын асуудлыг шийдвэрлүүлэх” 7876.6 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23.1-д “Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах тухай албан шаардлага бичлээ.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.22	Аудитын нэр: Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/188/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба	Мянган төгрөг: Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй	0	Албан шаардлага	ЗАА-ны дарга, нягтлан бодогч	Ц.Саруулсайхан, Н.Тунгалаг
2	Өмнөх оны албан шаардлага хэрэгжүүлээгүй	0	Албан шаардлага	Засаг дарга	Б.Анхбаяр
ДҮН		0			